



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2014 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 23

Мандалговь

Хөрөнгө данснаас хасах тухай

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1 “б”, 3.2.6 “г”, заалтуудыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Гурвансайхан сумын эрүүл мэндийн төв болон 9 жилийн сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 4'708'676 /дөрвөн сая долоон зуун найман мянга зургаан зуун далан зургаа/ төгрөгийн анхны өртөгтэй, үлдэгдэл өртөггүй 4 үндсэн хөрөнгийг хавсралтын дагуу данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг зохих журмын дагуу данс бүртгэлээс хасч, сумын өмч хамгаалах зөвлөлийн хяналтан дор устгахыг Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Э.Одончимэг, 9 жилийн сургуулийн захирал Ж.Цэцэгдэлгэр нарт тус тус даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

ДАРГА

С.БУДЖАВ



Аймгийн ИТХТ-ийн 2014 оны 02 сарын
17 өдрийн 23-р тогтоолын хавсралт

Акталж устгах эд хөрөнгө

Д/д	Нэр, төрөл	Эзэмшигч байгууллага	Хэмжих нэгж	Тоо	Анхны өртөг	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Склад	Хүн эмнэлэг	ш	1	3'931'620	3'931'620	0
2	Цогцос агуулах байр		ш	1	230'496	230'496	0
3	Халуун усны барилга	9 жилийн сургууль	ш	1	201'600	201'600	0
4	Склад		ш	1	344'960	344'960	0
Дүн				4	4'708'676	4'708'676	0